

1. Дараах зураг дээрх биес ямар энергитэй байна вэ?



- А. Харимхайн Б. Гэрэл
В. Хөдөлгөөн Г. Цахилгаан
Д. Дулаан

2. Нүүрс шатахад энерги энергид хувирдаг.
А. Дулаан/цахилгаан Б. Гэрэл/дулаан В. Хими/дулаан Г. Хими/цахилгаан Д. Хими/цахилгаан
3. Дараах биетүүдээс аль нь энергигүй вэ?
А. Сандал дээр байгаа ном Б. Үлээсэн бөмбөлөг В. Гадил жимс Г. Асаагүй чийдэн Д. Нүүрс
4. Байгаль орчинд хоргүй энергийн эх үүсвэрийг сонгоно уу?
А. Цөм Б. Түлш В. Харимхай Г. Нар Д. Хий
5. Дулааны цахилгаан станцын энергийн үндсэн эх үүсвэр нь юу вэ?
А. Нар Б. Ус В. Бензин Г. Салхи Д. Нүүрс


6. Дараах зурагт аль хүчийг дүрсэлсэн бэ?

- А. түлхэх хүч Б. агаарын эсэргүүцлийн хүч
В. хүндийн хүч Г. татах хүч Д. өргөх хүч




7. Олс таталтын тэмцээнд А баг 500Н хүчээр баруун тийш, Б баг мөн 500Н хүчээр зүүн тийш татав. Аль нь дийлэх вэ?
А. Б баг Б. А баг В. А ба Б баг дийлнэ Г. Аль нь ч дийлэхгүй Д. Зөв хариулт байхгүй байна.
8. 570Н жинтэй биеийн масс хэдэн кг-тай тэнцэх вэ?
А. 0,57кг Б. 5,7 кг В. 57 кг Г. 570 кг Д. 5700 кг
9. Шүхэртэй хүн агаарт удаан тогтох ба унах хөдөлгөөнд юу саад болдог вэ?
А. салхи Б. тулгуурын хүч В. хүндийн хүч Г. үрэлтийн хүч Д. агаарын эсэргүүцлийн хүч
10. Замын гадаргуугийн шинж чанар үрэлтийн үйлчлэлийг өөрчилдөг. Дараах өгүүлбэрүүдийг уншаад 2 зөв өгүүлбэрийг олж дугуйл.
А. Замын гадаргуу дээрх ус үрэлтийг нэмэгдүүлдэг.
Б. Замын гадаргуу дээрх тос үрэлтийг бууруулдаг.
В. Зам дээр тогтсон мөс үрэлтийн үйлчлэлийг өөрчлөхгүй.
Г. Барзгар зам үрэлтийн үйлчлэлийг нэмэгдүүлдэг.
Д. Гөлгөр зам үрэлтийн үйлчлэлийг өөрчлөхгүй.

11. Зурагт үзүүлсэн ачаанд үйлчлэх хүндийн хүчний чиглэлийг тодорхойлно уу. (Зураг 2)



- А. 1 Б. 2 В. 3 Г. 4 Д. 3 ба 4

12. Аяганд хийсэн харандаа гажиж харагддаг нь гэрлийн ямар үзэгдлээр тайлбарлагдах вэ?
А. Гэрэл хугарах Б. Гэрэл ойх В. Гэрэл тархах Д. Гэрэл шингэх Г. Аль нь ч биш
13. Доорх тохиолдлуудын алинд нь зургийн толинд үүссэн дүрсийг зөв илэрхийлсэн байна вэ?



- А. Б. В. Г.

14. Асуултын тэмдгийн оронд тохирох өнцгийг ол.




- А. 30° Б. 60° В. 90° Г. 120° Д. 50°

15. Улаан ба ногоон гэрлийн өнгүүдийг нэгтгэхэд ямар өнгийн гэрэл үүсэх вэ?
А. Ягаан Б. Цэнхэр В. Шар Г. Хөх Д. Хүрэн

Хоёрдугаар хэсэг Задгай даалгавар

2.1 Дараах диаграмаар өдрийн чийдэн дээр явагдсан энергийн хувирлыг харуулав. Диаграмыг ажиглан дараах дүгнэлтийг гүйцээнэ үү. /3 оноо/



Чийдэнд анх (1) Ж (2)..... энерги өгсөн ба чийдэн (3) Ж энергийг (4)..... энерги рүү, 25 Ж энергийг (5) энерги рүү хувиргажээ. Энд үр ашиггүй зарцуулагдсан энерги нь (6) энерги байна.

2.2 Гравитацийн хүч масстай бүх биесийн хооронд үйлчилдэг. Сарны хувьд дэлхийгээс бага масстай учир сарны зүгээс биеийг татах хүч дэлхийтэй харьцуулбал 6 дахин бага байдаг.

а. Саран дээр динамометрийн заалт 80 Н байсан бол ачааны массыг тооцоолно уу? /2 оноо/

б. Дэлхий дээр уг ачаатай динамометрийн заалт хэдэн Ньютон байх вэ? /1 оноо/

2.3 Гэрлийн тухай ойлголтуудаас зөв ба буруу аль нь болохыг тодорхойлооорой. /3оноо/


- А. Гэрэл нь зиг заг хэлбэрээр тархдаг. / /
Б. Гэрэл шулуун замаар тардаг. / /
В. Гэрэл хамгийн хурдан машинаас ч хурдан тархдаг. / /
Г. Гэрэл байшингийн булан тойрч чадна. / /
Д. Ширээн дээр гэрэл тусгахад толин ойлтоор гэрэл ойно. / /
Е. Сар бол гэрэл үүсгэгч юм. / /

2.4 Гэрлийн цацраг хавтгай толинд 55 градус өнцгөөр туссан бол

а. Туссан ба ойсон цацрагийг зургаар дүрслээрэй. /1 оноо/

б. Туссан ба ойсон цацрагийн хоорондох өнцөг хэдэн градус байх вэ? /2 оноо/

2.5 F үсгийн хавтгай толинд үүссэн дүрсийг байгуулна уу.



/3оноо/

Хариу

1	A	Хоёрдугаар хэсэг 2.1 100Ж (1), цахилгаан энерги (2), 75Ж, гэрлийн (3), 25Ж (4), дулааны (5), дулааны (6) 2.2 А.50 кг Б.480Н 2.3 А. Буруу Б. Зөв В. Зөв Г. Буруу Д. Буруу Е. Буруу 2.4 А.Туссан ба ойлсон цацраг зөв зурсан бол 1 оноо. Б.110° 2.5 Зөв зурсан бол 3 оноо.
2	B	
3	Г	
4	Г	
5	Д	
6	Д	
7	Г	
8	В	
9	Д	
10	Б, Г	
11	В	
12	А	
13	В	
14	Б	
15	А	